



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 5/05

Баянхутаг сум

Ажилд томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралт, 2024 оны 238 дугаар тогтоолын 10 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ.

1. Болдбаатар овогтой Сувдыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнаар томилон ажиллуулсугай.

2. Албан тушаалын тодорхойлолттой танилцан, заагдсан ажил үүргээ болон байгууллагын захиргаанаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэн ажиллахыг Б.Сувдад даалгасугай.

3. Б.Сувдын сарын үндсэн цалинг ТҮМ-3 шатлалд, 1283000 / нэг сая хоёр зуун наян гурван мянган/ төгрөгөөр тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Ууганнавч/-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧИЙГ ХАВСРАН

ГҮЙЦЭТГЭГЧ

Т.НАРАНЦЭЦЭГ

